



МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 09 сарын 01 өдөр

Дугаар A/219

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 47.2, 263.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Төлбөртэй этгээдийн бүртгэл хөтлөх, тодорхойлолт, лавлагаа гаргах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөргүй талаарх тодорхойлолтын загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /бригадын генерал Ц.Амгаланбаяр/-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2002 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийн 251 дүгээр тушаалыг хүчингүйд тооцсугай.



С.БЯМБАЦОГТ

ТӨЛБӨРТЭЙ ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ТОДОРХОЙЛОЛТ, ЛАВЛАГАА ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Шүүхийн шийдвэрээр тогтоосон мөнгөн төлбөрийн үүргийг биелүүлээгүй этгээдийн талаар төлбөртэй этгээдийн бүртгэл хөтлөх, улсын хэмжээнд нэгдсэн бүртгэлийн сан үүсгэх, хүсэлт гаргасан этгээдэд тодорхойлолт, лавлагаа олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Төлбөртэй этгээдийн бүртгэл хөтлөх ажиллагаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон энэ журмын заалтыг мөрдлөг болгон ажиллана.

Хоёр. Төлбөртэй этгээдийн бүртгэл хөтлөх, тодорхойлолт, лавлагаа авах

2.1. Шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй этгээдэд холбогдох гүйцэтгэх баримт бичиг болон шийдвэр гүйцэтгэх ажиллагааны мэдээллийг цахим хэлбэрээр бүртгэж, улсын хэмжээнд төлбөртэй этгээдийн нэгдсэн бүртгэлийг Шийдвэр гүйцэтгэх алба хөтөлнө.

2.2. Төлбөртэй этгээдийн бүртгэлд дараах мэдээллийг тусгана.

2.2.1. шүүхийн шийдвэр, гүйцэтгэх хуудасны дугаар, төлбөрийн шаардлага;

2.2.2. төлбөр төлөгч иргэний овог, нэр, регистрын дугаар, хуулийн этгээдийн оноосон нэр, улсын бүртгэлийн дугаар, оршин суугаа /оршин байгаа/ хаяг;

2.2.3. төлбөрийн хэмжээнд орсон өөрчлөлт.

2.3. Төлбөртэй этгээдийн нэгдсэн бүртгэлээс иргэн хуулийн этгээдийн хүсэлтээр шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөртэй эсэх талаар тодорхойлолт, лавлагааг хүсэлт гаргагч иргэн, хуулийн этгээдэд олгож болно.

2.4. Энэ зүйлийн 2.3-д заасан тодорхойлолт, лавлагааг хүсэлт гаргагчийн дараах баримт бичгийг үндэслэн төлбөртэй олгоно.

2.4.1. иргэний үнэмлэх, түүний хуулбар болон төрийн үйлчилгээний цахим машинаас олгосон иргэний бүртгэлийн лавлагаа, гадаад улсын иргэний паспорт;

2.4.2. хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

2.4.3. орлогын баримт.

2.5. Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан иргэн, хуулийн этгээд шүүхийн шийдвэрээр тогтоосон төлбөртэй эсэх талаар мэдээлэл хүссэн тохиолдолд лавлагааг төлбөргүй олгоно.

2.6. Цахим сангийн ашиглалтын зардлын тооцоог үндэслэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын санхүүгийн асуудал хариуцсан нэгж энэ зүйлийн 2.4-д заасан тодорхойлолтын үнийг тогтоож, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга батална.

2.7. Төлбөртэй этгээдийн нэгдсэн бүртгэлээс тодорхойлолт, лавлагааг цахим хэлбэрээр олгож болно. Цахим лавлагаа авах хүсэлт ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн баримт бичиг нь энэ зүйлийн 2.4-д заасан шаардлага хангасан байна.

Гурав. Тодорхойлолт, лавлагаа олгох ажиллагаа

3.1. Шүүхийн шийдвэрээр төлбөргүй талаарх тодорхойлолтыг нэгдсэн дугаартай хэвлэмэл хуудсаар, төлбөртэй эсэх талаарх лавлагааг албан бичгээр хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд олгоно.

3.2. Шүүхийн шийдвэрээр төлбөртэй иргэн, хуулийн этгээдэд тодорхойлолт олгохгүй бөгөөд төлбөртэй талаар лавлагаа өгч болно.

3.3. Шүүхийн шийдвэрээр төлбөртэй эсэх талаар тодорхойлолт, лавлагааг орон нутагт Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /хэлтэс/-ын ахлах шийдвэр гүйцэтгэгч, нийслэлд Шийдвэр гүйцэтгэх албаны мэдээлэл, лавлагаа хариуцсан нэгж олгох бөгөөд тодорхойлолт, лавлагаа нь 30 хүртэл хоногийн хугацаатай байна.


3.4. Төлбөртэй этгээдийн нэгдсэн бүртгэлээс олгосон тодорхойлолт, лавлагааны баримт бичгийг архивын нэгж болгон хадгална.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Төлбөртэй этгээдийн бүртгэлийн сангаас иргэн, хуулийн этгээдэд бусад этгээдийн талаарх мэдээлэл өгөхийг хориглоно.

4.2. Төлбөртэй этгээдийн нэгдсэн бүртгэлийн санд бүртгэгдсэн мэдээллийг бусдад задруулсан эсхүл төлбөртэй этгээдэд тодорхойлолт олгосон бол гэм буруутай этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---oo0oo---



Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны
09 дүгээр сарын 04-ны өдрийн 4219 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР**

ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБА

Шуудангийн хайрцаг, хаяг: утас:
Цахим хуудас: э-шуудан:

ТОДОРХОЙЛОЛТ

... оны ... дүгээр Дугаар...
сарын...-ны өдөр /аймаг, нийслэл/

Регистрийн /улсын бүртгэлийн дугаар/ _____ дугаартай
_____ оршин суух /оршин байгаа/
хаягтай _____ нь шүүхийн шийдвэрээр
иргэн, хуулийн этгээдэд төлбөргүй болохыг тодорхойлов.

Хүчинтэй хугацаа: ... хоног

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН,
/гарын үсэг, тэмдэг/

0000001